



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

“Ситизенс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, шалгалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ситизенс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Ситизенс ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-г, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 3 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

050174